



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.10.08-10.12

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын хөрөнгийн зах зээлийн S&P 500 индекс лхагва гарагт 5%-аар буурчээ. Тус индексийн сагсанд багтдаг аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш унасан бол өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш өссөн үзүүлэлттэй байна. Засгийн газрын үнэт цаасны өгөөж нэмэгдэж, худалдааны маргааны асуудал даамжиран, дэлхийн эдийн засгийн хөгжил саарч байгаа зэрэг үйл явдал хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

БНХАУ хилээр оруулах зөвшөөрөлгүй тансаг загварын цүнх болон бусад бараа бүтээгдэхүүнийг хураан авч эхэлсэн талаар мэдээлэл гарч, тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханш унаж эхлэв.

9-р сард хэрэглээний үнийн индексийн түвшин сүүлийн нэг жилийн хугацаанд үзэгдээгүй доод түвшинд хүрч 2.3%-тай тэнцжээ. Харин тус хугацаанд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өссөн нь хэрэглээний үнийн индексийн түвшин цаашид нэмэгдэх шалтгаан болж магадгүй байна.

Европ: Хөрөнгө оруулагчид бодлогын хүүний түвшин нэмэгдэх нь дэлхийн эдийн засгийн хөгжлийг удаашруулна хэмээн үзэж, Европын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд уналттай хаагдлаа. Хятадын эдийн засгийн удаашрал, тус улсын гаалийн бодлого зэрэг нь тансаг зэрэглэлийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч компаниудын хувьцааны ханшид сөргөөр нөлөөлжээ.

Энэ долоо хоногт Италийн FTSE MIB индекс 5 орчим хувиар, Их Британийн FTSE 100 индекс 4.4%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хөрөнгө оруулагчид Итали улсын санхүүгийн тогтвортой байдалд эргэлзэж, тус улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж өсөн, 3.71 хувьд хүрлээ. Италийн Ерөнхий сайд ноён Маттео Сальвини 2019 оны төсөвт ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй, мөн тус улсын популист Засгийн газар Европын холбооны эсэргүүцлийг үл хайхран эрүүл мэнд, тэтгэврийн зардлыг нэмж, татварын хэмжээг бууруулах өөрийн амлалтаасаа татгалзахгүй хэмээн мэдээлсэн.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индекс уналттай хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг суларч 112.31 болов.

Японы Nikkei 225 индекс 4.6%-аар унаж, 9-р сарын дунд үеэс хойш хамгийн доод түвшинд хүрчээ. Аж үйлдвэр, мэдээлэл технологийн салбарын компаниуд, тэр дундаа БНХАУ руу бараа бүтээгдэхүүнээ экспортолдог компаниудын хувьцааны ханш ихээр буурсан үзүүлэлттэй байна.

Хувьцаат компаниудын 3-р улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан гарч, Японы хөрөнгийн зах зээлд эерэг нөлөө үзүүлэх хэдий ч АНУ, БНХАУ-ын худалдааны маргаан зах зээлд тогтворгүй байдал үүсгэсээр байна хэмээн зах зээлийн оролцогчид үзжээ.

БНХАУ: БНХАУ банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулснаар эдийн засагт нэмэлт 175 тэрбум ам.доллар эргэлтэнд орлоо. Тус улсын Засгийн газар худалдааны маргааны асуудал даамжирч буй энэ үед бизнесийн орчинг дэмжих зорилгоор ийм шийдвэр гаргажээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,463.15	0.31% ▲
Dow Jones	АНУ	25,339.99	-4.19% ▼
S&P 500	АНУ	2,767.13	-4.10% ▼
Nasdaq	АНУ	7,496.89	-3.74% ▼
S&P/TSX	Канад	15,414.29	-3.34% ▼
FTSE 100	Их Британи	6,995.91	-4.41% ▼
S&P/ASX 200	Австрали	5,895.70	-4.69% ▼
Nikkei 225	Япон	22,694.66	-4.58% ▼
Hang Seng	Хонг Конг	25,801.49	-2.90% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.89
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.63
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	97.02
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.77
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.39
TDBM' 2020	USD	9.3%	105.76

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.280	0.00 ▲
Libor 3M	2.436	0.03 ▲
Libor 6M	2.652	0.03 ▲
Libor 1YR	2.963	0.01 ▲
US 6M Bond	2.431	0.03 ▲
US 2YR Bond	2.849	-0.04 ▼
US 3YR Bond	2.935	-0.05 ▼
US 5YR Bond	3.006	-0.06 ▼
US 10YR Bond	3.150	-0.08 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.10.12	Өөрчлөлт
USD	2,563.84	-0.13% ▼
CNY	370.77	-0.79% ▼
EUR	2,972.90	0.65% ▲
RUB	38.86	0.83% ▲
KRW	2.26	-0.44% ▼
JPY	22.83	1.24% ▲
CAD	1,970.29	-0.72% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,221.72	2.13% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.64	1.24% ▲
Зэс	USD/lb.	281.30	2.53% ▲
Нүүрс	USD/MT	108.32	-5.25% ▼
WTI газрын тос	USD/bbl.	72.14	-2.14% ▼
Brent газрын тос	USD/bbl.	81.43	-2.22% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.21	0.94% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. IX	5.70%
Бодлогын хүү	2018. IX	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VIII	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VIII	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VIII	10.60%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 36 компанийн 2,152.8 сая төгрөгийн 13,408,495 ширхэг хувьцаа арилжигдав.


“Э-транслогистикс” /ETR/ компанийн хувьцаа 44.32%-аар буюу хамгийн ихээр өсч 95.25 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 13.73%-аар буурч 660 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 10,489 ширхэг үнэт цаас 1,097.2 сая төгрөгөөр арилжаалагджээ.


10-р сарын 12-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,407.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,463.15 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.31%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	3,250.0
Зах зээлийн үнэлгээ	2,407,789.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,463.15	0.31% ▲
MSE I индекс	9,792.43	0.00% ▼
MSE II индекс	8,912.39	-2.79% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Женко тур бюро	10,359,954	725,204,280
Мандал даатгал	130,647	638,953,348
Ард даатгал	368,367	316,886,871
ЛэндМН ББСБ	2,135,165	154,254,693
Говь	2,747	92,980,580

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Э-транс ложистикс	95.25	44.32% ▲
Багануур	1,790.00	15.34% ▲
Шивээ овоо	2,100.00	5.00% ▲
Махимпекс	2,550.00	4.55% ▲
Монгол шуудан	569.00	2.52% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	660.00	-13.73% ▼
Монгол базальт	320.68	-12.57% ▼
Атар-Өргөө	70,050.00	-12.44% ▼
Хөвсгөл алтан дуулга	700.00	-10.26% ▼
Улсын их дэлгүүр	490.00	-7.37% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	4,806,640,963
БиДиСек	1,681,377,820
Голомт капитал	974,929,275
Ард секьюритиз	452,207,771
Ти Ди Би Капитал	154,789,468

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	571.00	608,297
Таван толгой	7,700.00	405,522
Говь	33,880.00	264,302
МИК	10,970.00	227,181
Сүү	221.97	76,358

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-01/08/19-A0285-13.745	140	14,169,400	101,210	101,210	104	13.745%
2	ZGEB-BD-09/05/19-A0242-15.995	58	5,906,720	101,840	101,840	104	15.995%
3	ZGEB-BD-10/10/19-A0336-13.945	250	25,465,000	101,860	101,860	104	13.945%
4	ZGEB-BD-11/04/19-A0230-18	338	34,624,720	102,440	102,440	104	18.000%
5	ZGEB-BD-14/03/19-A0219-18	147	14,989,590	101,970	101,970	104	18.000%
6	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	1,097	114,998,510	104,830	104,830	156	14.500%
7	ZGEB-BD-18/07/20-A0275-15.14	3,920	413,873,600	105,580	105,580	156	15.140%
8	ZGEB-BD-22/05/20-A0248-15.87	100	10,610,000	106,100	106,100	156	15.870%
9	ZGEB-BD-24/10/19-A0348-13.955	1,640	167,214,400	101,960	101,960	104	13.955%
10	ZGEB-BD-25/04/20-A0236-16.993	1,289	138,374,150	107,350	107,350	156	16.993%
11	ZGEB-BD-26/09/19-A0326-13.955	1,000	101,780,000	101,780	101,780	104	13.955%
12	ZGEB-BD-27/03/20-A0225-18	510	55,227,900	108,280	108,280	156	18.000%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дютти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хувьцаа хуваах тухай шийдвэрийг баталлаа

Монголын хөрөнгийн биржийн 1-р ангилалд бүртгэлтэй “Говь” ХК-ийн 2018 оны 10-р сарын 3-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 01 тоот тогтоолоор компанийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 7,801,125 ширхэг энгийн хувьцааг 100 хувааж, нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, нийт 780,112,500 ширхэг хувьцаа болгох шийдвэрийг гаргаж, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар холбогдох материалыг Монголын хөрөнгийн биржид ирүүлсэн байна.

Монголын хөрөнгийн бирж нь “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу ажлын 15 хоногт багтаан үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, СЗХ-нд шийдвэрийг хүргүүлэх бөгөөд СЗХ үнэт цаасны бүртгэлд оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд тухайн хувьцааны үнэт цаасны арилжааг түр зогсоож, холбогдох бүртгэлийн өөрчлөлт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд хийгдэж дууссаны дараа үнэт цаасны арилжааг эхлүүлэх юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



Бүртгэлтэй үнэт цаасны чанарыг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө батлан ажиллаж байна

Монголын хөрөнгийн бирж нь бүртгэлтэй хувьцаат компаниудын хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг сайжруулж, арилжигдаж буй бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиглэлээр ажлын төлөвлөгөө батлан ажиллаж байна. Тус төлөвлөгөөт ажлууд нь 2019 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэл үргэлжлэх бөгөөд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх юм. Үүнд:

1. МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон Бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэггүй, зохих шалгуур, шаардлагыг хангахгүй байгаа, арилжаа зогссон компаниудын талаар олон нийтэд тухай бүр мэдээлэх;
2. СЗХ-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэлгүй, анхдагч зах зээлийн арилжаа нь явагдаагүй компаниудыг биржийн бүртгэлээс хасах;
3. Үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа нь сэргээгүй компаниудад хугацаатай үүрэг өгөх бөгөөд уг хугацаанд арилжааг зогсоох нөхцөл шалтгаан арилаагүй тохиолдолд журамд заасны дагуу шат дараалсан арга хэмжээ авах;
4. Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр, хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй компаниудад албан үүрэг өгөх бөгөөд үүргийн гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд биржийн бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авах.

Иймд, холбогдох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, журмын шалгуур, шаардлагыг хангаж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн зүгээс бүртгэлтэй компаниудад анхааруулж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ҮЦТХТ: Үнэт цаасны данс нээлгэсэн харилцагчдын тоо нэг сая давлаа

Үнэт цаасны данстай харилцагчдын тоо нэг сая давсан талаар Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв мэдээллээ. 2018 он гарснаас хойш сард дунджаар 4,000-5,000 үнэт цаасны данс нээжээ.

Харин 8-р сард 8,000, 9-р сард 24 мянган данс нээсэн байна. Өөрөөр хэлбэл 9-р сард өмнөх сараас гурав дахин их үнэт цаасны данс нээгээд байгаа ажээ.

Үнэт цаасны данс нээлгэх иргэдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголын Хөрөнгийн биржийн үнэт цаасны дансны бүртгэлийг гүйцэтгэх “Миллениум CSD” системийг 11-р сарыг дуустал амралтын өдрүүдэд ажиллуулахаар болсон байна.

Одоогоор нийт 2.5 сая иргэнд “Эрдэнэс Тавантолгой”-ийн 1,072 ширхэг хувьцааг эзэмшүүлээд байгаа аж. Харин зарим иргэдийн хувьцааны үлдэгдэл 536, 750 гэх мэт өөр өөр байгаа нь 2011 оноос хойш Хүний хөгжлийн сангаас хувьцаа эзэмшигчдэд хувь хүртээсэн нь нөлөөлжээ. Тухайлбал, 536 ширхэг хувьцаатай үлдсэн иргэд 2011 онд оюутны сургалтын төлбөрт 500 мянган төгрөг авч байсан, 750 ширхэг хувьцаатай үлдсэн иргэд 2016 онд Засгийн газарт хувьцаагаа 300 мянган төгрөгөөр үнэлэн худалдсан гэдгийг мэдээлж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Эрдэнэс Тавантолгой” ХК ТУЗ-ийн гишүүдэд шинэчлэв

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал боллоо. Хурлаар компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталж, Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой зарим асуудлыг хэлэлцэж, холбогдох чиг үүргийг ТУЗ-ийн гишүүдэд өгсөн байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 30 хүртэлх хувийг Монголын Хөрөнгийн биржээр арилжаалах бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байгаа бөгөөд гадны биржүүдээс Нью-Йорк, Хонгконгийн Хөрөнгийн биржийг сонгон судалж байна. Тус компани олон улсын зөвлөхүүд шалгаруулахаар тендерээ зарлаад байгаа юм. Мөн компанийн засаглалыг сайжруулах, ил тод нээлттэй байлгах, санхүүгийн ил тод байдлаа хангах зэрэгт анхаарч байгаа гэдгийг тус компанийн Гүйцэтгэх захирал Ч.Ганхуяг онцоллоо. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ дахь Төрийн төлөөлөл долоон гишүүний бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна. Харин ТУЗ-ийн хараат бус дөрвөн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэхийг хойшлуулжээ.

10-р сарын 8-ны байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК 7.78 сая тонн нүүрс олборлож, 10 сая тонн борлуулаад байна. Тус компани нүүрсний олборлолтоо энэ онд 13 сая тонн, ирэх онд 15 сая тонн, 2020 он гэхэд 20 сая тоннд хүргэх чиглэлтэй байгаа юм.

9-р сарын байдлаар тус компанийн цэвэр ашиг 483 тэрбум төгрөг болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮСХ: Нүүрсний худалдаа нийт экспортын 40%-ийг бүрдүүлэв

Эрдсийн экспорт оны эхний есөн сарын байдлаар мөнгөн дүнгээр 4.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 24.3%-иар өссөн дүнтэй гарлаа. Энэ дундаа нүүрсний экспорт орлогын дүнгээр 2.13 тэрбум ам.долларт хүрсэн нь 23.3%-ийн өсөлтийг харуулж байгаа юм. Эрдсийн экспорт дотроо орлогын дүнгээр тэргүүлж буй нүүрс улсын нийт экспортын 40%-ийг дангаараа бүрдүүлсэн дүнтэй байна.

Нүүрсний экспортын биет хэмжээ эхний есөн сарын байдлаар 27.4 орчим сая тоннд хүрч өмнөх оны мөн үеийнхээс 6.2%-иар өссөн дүнтэй гарлаа. Сарын дүнгээр өнгөрсөн есдүгээр сард 3.58 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх наймдугаар сарынхтай харьцуулахад 20%-иар өссөн дүн боллоо.

Зэсийн баяжмалын экспортын тухайд оны эхний есөн сард 1 сая 73 мянган тонныг гадагш нийлүүлж, 1.5 орчим тэрбум ам.долларын орлого олсон байна. Энэ нь зэсийн баяжмалын экспорт биет жингээр 1.1%-иар буурсан бол орлогын түвшин 28.7%-иар дээшиллээ. Харин боловсруулсан цэвэр зэсийн экспортын хувьд мөн хугацаанд жингээр 10.05 орчим мянган тонн, мөнгөн дүнгээр 65 сая ам.долларт хүрсэн нь биет жингийн хувьд 17.2%-иар, орлогын дүн 6.4%-иар тус тус буурсан дүнтэй гарав.

Боловсруулаагүй газрын тосны экспорт 4.8 сая баррельд хүрч, 316 сая ам.долларын орлоготой ажилласан дүнтэйгээр оны эхний есөн сарыг давлаа. Энэ дүн нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад жингээр 14.6%-иар буурсан боловч орлогын дүн нь 16.1%-иар өссөнийг илтгэв.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны тухайд мөн хугацаанд 3.4 тонныг экспортолж, 144.5 сая ам.долларын орлогын дүнгийн биелэлттэй гарлаа. Энэ нь жин болон орлогын хувьд бараг 64%-иар буурсан үзүүлэлт юм. Гэхдээ Монголбанкны алт худалдан авалтын хэмжээ оны эхний есөн сарын байдлаар 14.3 тоннд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 377.7 кг-аар буюу ялимгүй багассан тухай тус банк мэдээлээд байгаа юм.

Төмрийн хүдрийн экспортын тухайд оны эхний есөн сард 5.3 сая тоннд хүрч, 240.4 сая ам.долларт хүрсэн нь биет жингээр 21.9%-иар, орлогын дүн нь 3.8%-иар өссөн үзүүлэлттэй гарлаа.

Цайрын хүдэр, баяжмалын экспорт мөн хугацаанд 92.2 мянган тонн болж, орлогын дүн нь 153.46 орчим сая долларт хүрчээ. Цайрын экспорт ийнхүү жингээр 1.6%-иар, орлогын дүн нь 14.9%-иар тус тус өсөв.

Жоншны хүдэр, баяжмалын экспортын тухайд оны эхний есөн сарын байдлаар 344.7 мянган тонныг гадагш нийлүүлж, 115.7 сая ам.доллар олсон нь биет жингээр 59.8%, орлогын дүнгээр 2.1 дахин өссөн дүнтэй гарлаа.

Молибденийн баяжмалын экспорт эхний есөн сарын байдлаар 4.4 мянган тоннд хүрч, 36 сая ам.доллартай тэнцсэн нь биет жингээр 10.1%-иар буурсан ч, үнийн дүнгийн хувьд 30.8%-иар нэмэгдсэн дүнг илтгэлээ.

Хар тугалгын хүдэр баяжмалын экспортын тухайд 15 мянган тоннд хүрч, 38 орчим сая ам.доллартай тэнцсэн нь жингээр 27.1%-иар, орлогын хувьд 26.6%-иар тус тус нэмэгдсэн дүнтэй гарлаа.

Гянтболдын экспорт оны эхний есөн сард 458.4 тоннд хүрч, 5.06 сая ам.долларын орлого олсон нь өмнөх оны мөн үеийнхээс жингийн хувьд 37.8%-иар, орлогын дүн 4.4%-иар тус тус буурсан байна.

Эх сурвалж: MongolianMiningJournal.mn

Дэлхийн түүхий ноолуурын 45 хувийг Монгол Улс хангаж байна

БНХАУ-аас экспортлох ноос, ноолууран бүтээгдэхүүнд АНУ импортын тариф тогтоогоод байгаа юм. "Энэ нь Монголын үйлдвэрлэгчдэд давуу тал бий болгож байна" гэж "Сор Кашемир"-ийн Гүйцэтгэх захирал үзэж байгаагаа илэрхийллээ. Тиймээс тус компани зах зээлээ тэлж, АНУ-д бүтээгдэхүүнээ гаргахаар төлөвлөж байгаа ажээ.

Ноолууран бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэн боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор "Ноолуур" хөтөлбөрийг эхлүүлээд байна. Энэ хүрээнд 2017 оны байдлаар нийт ноолуурын экспортын 20 хувийг бэлэн бүтээгдэхүүн эзэлж байсан бол 2021 онд 60 хувьд хүргэхээр Засгийн газар зорьж байгаа юм.

Дэлхийн түүхий ноолуурын 45 хувийг Монгол Улс хангадаг талаар "Говь" компани мэдээлж байв. Тус компани оны эхний 8 сард нийт 93.6 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 35.8 хувийг гадаад зах зээлд борлуулжээ. "Говь" компани жил бүр гадаад зах зээлд цар хүрээгээ тэлж, 13 орны 34 хотод нийт таван салбар дэлгүүр, 53 франчайз дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүнээс гадна монгол залуус "Yakmere" брэндийн сарлагийн хөөврөн хувцсыг "Kickstarter"-т санал болгож, 16 мянган ам.долларын санхүүжилт татахаар боллоо. Монгол сарлагийн хөөврийг ноолууртай дүйцэхүйц бүтээгдэхүүн болгож, дэлхийн зах зээлд экспортлох зорилттой ажиллаж байгаа энэхүү старт-ап компани бүтээгдэхүүнээ анх санал болгохдоо 10 мянган ам.долларын санхүүжилт татахаар төлөвлөж байжээ. Харин ердөө хоёр хоногийн дотор энэхүү зорилтдоо хүрчээ. Европыг зорилтот зах зээлээрээ сонгосон тус брэнд тансаг зэрэглэлийн сарлагийн хөөврөн бүтээгдэхүүнээ ирэх 12-р сараас эхлэн ойролцоогоор 175 ам.доллараар зах зээлд нийлүүлэхээр төлөвлөж байгаа юм байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

Шатахууны жижиглэнгийн үнэ литр тутамд 60-90 төгрөгөөр нэмэгдлээ

Шатахуун импортлогч компаниуд шатахууны жижиглэнгийн үнээ нэмлээ. Тухайлбал, "Шунхлай" компани 10-р сарын 5-ны өдрөөс эхлэн АИ-92, АИ-80, АИ-95 бензиний үнийг литр тутамд 60 төгрөгөөр, дизель түлшний үнийг 90 төгрөгөөр нэмсэн байна.

Мөн "Сод Монгол" компани Улаанбаатар хотын захын дүүргээр байрлаж буй шатахуун түгээх 12 станцдаа АИ-92 бензиний үнийг литр тутамд нь 50 төгрөг, дизель түлшийг 90 төгрөгөөр тус бүр нэмж байгаа талаар мэдэгдлээ. Шатахууны хилийн үнэ өссөн болон ам.долларын ханш чангарсан нь дотоодод жижиглэнгийн үнээ нэмэх шалтгаан болсон гэж шатахуун импортлогчид тайлбарлаж байна.

"Шунхлай" компани цаашид үнээ дахин нэмэх магадлалтай гэсэн бол "Сод Монгол" компани 10-р сард дизель түлшний хилийн үнэ 85 ам.доллараар өссөн гэдгийг онцоллоо. Шатахуун импортлогч компаниуд өнгөрсөн 8р сараас эхлэн шатахууны үнэ өсөх талаарх мэдэгдлээ Засгийн газарт хүргүүлсэн ажээ.

"Роснефть" компани 10-р сард Монгол Улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүнийхээ хилийн үнийг тонн тутамд нь 45-85 ам.доллараар нэмсэн талаар Ашигт малтмал, Газрын тосны газар мэдээллээ. Ингэснээр АИ-92 автобензиний үнэ тонн нь 766 ам.доллар, дизелийн түлшнийх 758 ам.доллар болсон байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монголын эдийн засгийн 9-р сарын байдал

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2018 оны 9-р сарын эцэст 17.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 471.0 (2.7%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.2 (21.4%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2018 оны 9 дүгээр сарын эцэст 929.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.6 (0.2%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 50.2 (5.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 9-р сарын эцэст 16.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 399.4 (2.5%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.9 (21.8%) их наяд төгрөгөөр өсөв.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 9-р сарын эцэст 991.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 27.5 (2.7%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 164.1 (19.8%) тэрбум төгрөгөөр өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.1 хувийг эзэлж, өмнөх сараас 0.3 өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр тус тус буурчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2018 оны эхний 9 сарын байдлаар 6.5 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6.3 их наяд төгрөгт хүрлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2017 оны эхний 9 сард 737.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байсан бол 2018 оны эхний 9 сард 241.7 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Энэ оны 9-р сард өмнөх сараас улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 65.3 тэрбум төгрөгөөр буурч, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 223.3 тэрбум төгрөгөөр өслөө.

Татварын нийт орлого 5.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.4 (31.8%) их наяд төгрөгөөр өсөхөд тусламжийн орлого 5.7 (27.3%) тэрбум төгрөг, тусгай зориулалтын орлого 0.3(2.7%) тэрбум төгрөг, хөрөнгийн орлого 0.2(29.9%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч нэмэгдсэн өртгийн албан татвар 380.1 (32.9%) тэрбум төгрөг, орлогын албан татвар 328.6 (30.3%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 213.9 (23.1%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 190.4 (52.8%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 137.4 (39.1%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 131.1 (31.9%) төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 80.6 хувийг татварын орлого, 10.2 хувийг татварын бус орлого, 6.8 хувийг ирээдүйн өв сангийн орлого, 2.5 хувийг тогтворжуулалтын сангийн орлого эзэлж байна. Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2018 оны эхний 9 сард 6.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 502.0 (8.7%) тэрбум төгрөгөөр өсөхөд хүүгийн зардал 33.6(4.3%) тэрбум төгрөг, татаас 28.0(15.4%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч урсгал зардал 323.9 (6.7%) тэрбум төгрөг, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 141.1 (99.5%) тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 36.9 (4.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.



Монгол Улс 2018 оны эхний 9 сард 152 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9.6 тэрбум америк доллар, үүнээс экспорт 5.3 тэрбум америк доллар, импорт 4.4 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2018 оны 9-р сард экспорт 611.5 сая америк долларт, импорт 549.0 сая америк долларт хүрч, өмнөх оны мөн үеэс экспорт 131.0 (27.2%) сая америк доллараар, импорт 172.5 (45.8%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 (25.0%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 699.9(15.3%) сая америк доллараар, импорт 1.2 (39.2%) тэрбум америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2017 оны эхний 9 сард 1.5 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2018 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеэс 526.5 (36.1%) сая америк доллараар буурч, 931.7 сая америк долларт хүрчээ. Харин гадаад худалдааны тэнцэл 2018 оны 9-р сард 62.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 41.5 (39.9%) сая америк доллараар буурсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 9 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.1 хувиар буурч, өмнөх оны эцсээс 4.6 хувь, өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 9-р сард өмнөх оны мөн үеэс 5.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 6.2 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 8.8 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.0 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 11.1 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 15.8 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлэг дүнгээрээ 4.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.